

З.Доржсүнцэл (ЗССТ)
Д.Очижсандан-о (штаб)
Д.Аялангуяа (шилох)



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Дугаар A/182

Эрдэнэбулаг сүм

+ Бүх тогтолцоот залвар,
зөвлөлийн төгрөгийн
+ Халг - от дэдэс оноос мэргэжлийн
+ Дэлхийн тогтолцоог хамгаалж
+ Өвгө - Гучин хамгаалж
29/03/2020

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан
сэргийлэх хог хаягдал цэвэрлэх,
халдваргүйтгэл хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх, халдвараас хамгаалах зорилгоор аймаг, сумын хэмжээнд ахуйн хог хаягдал цэвэрлэх, халдваргүйтгэл хийх ажлыг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдруудэд зохион байгуулсугай.


2. Хариуцсан байгууллага, аж ахуйн нэгжийн дотоод цэвэрлэгээ, халдваргүйтгэлтийг зохион байгуулж хийлгэхийг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /Н.Цэвэгдорж/, Онцгой байдлын газрын дарга /хурандаа Д.Эрдэнэбаатар/, Эрүүл мэндийн газрын дарга /Р.Гандиймаа/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, шуурхай штабын дарга /Б.Болормаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХНАСАН



651200500